

ТАНИЛЦУУЛГА

Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 57 дугаар зүйлийн 57.4 дэх хэсэгт улс төрийн болон тусгай албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагч /сум, дүүргийн Засаг дарга, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын орлогч, зэвсэгт хүчин, хилийн цэрэг ба дотоодын цэрэг, онцгой байдал, тагнуул, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тусгай албан тушаалаас бусад/-ийн албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг төрийн албаны төв байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтоохоор заасан.

Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын 57 дугаар зүйлийн 57.4 дэх хэсэгт тусгайлан заасан төрийн улс төрийн болон тусгай албан тушаалуудад:

1. Бүх шатны шүүхийн шүүгч, прокурор /ТАТХ 13.1.1/
2. Авлигатай тэмцэх газрын удирдах, гүйцэтгэх албан тушаал /ТАТХ 13.1.3/
3. Үндэсний болон орон нутгийн аудитын газрын удирдах, гүйцэтгэх албан тушаал /ТАТХ 13.1.3/
4. Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн ажлын албаны албан тушаал /ТАТХ 11.1.11/
5. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, хот, тосгоны захирагч /ТАТХ 12.1/
6. Шүүхийн шинжилгээний байгууллагын шинжээч, мэргэжилтэн /ТАТХ 13.1.6/ хамаарч байна.

Эдгээр албан тушаалуудын цалингийн хэмжээ, нэмэгдлийг салбарын хуулиар нь тусгайлан зохицуулж, УИХ-аас батлахаар заасан байна.

№	Хууль тогтоомжийн нэр	Хуулийн зохицуулалт	Батлагдсан огноо
1	Төрийн аудитын тухай хууль	14.4.Төрийн аудитын байгууллагын ажилтнуудын цалин хөлс, урамшууллын тогтолцоо төрийн албаны тухай хууль тогтоомжийн хүрээнд өөрийн онцлогт тохирсон байх бөгөөд тэдгээрийн албан тушаалын цалингийн хэмжээг Улсын Их Хурал тогтооно. 13.11.Монгол Улсын Ерөнхий аудиторын цалин, зэрэг зиндааг Улсын Их Хурал тогтооно.	2003 оны 1 дүгээр сарын 03-ны өдөр
2	Прокурорын тухай	59.3.Прокурорын цалин хөлс нь албан тушаалын цалин, албан ажлын онцгой	2017 оны 6 дугаар сарын 09-ний өдөр

	/Шинэчилсэн найруулга/	нөхцөл, төрийн алба хаасан хугацаа, зэрэг дэв, эрдмийн зэргийн нэмэгдлээс бүрдэнэ. Прокурорын албан тушаалын цалингийн сүлжээ, нэмэгдлийн хэмжээг Улсын Их Хурал тогтооно.	
3	Авлигын эсрэг хууль	29.6.Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга, албан хаагчийн цалин хөлс нь албан тушаалын цалин, албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, зэрэг дэвийн, эрдмийн зэргийн нэмэгдлээс бүрдэх бөгөөд тэдгээрийн хэмжээг Улсын Их Хурал тогтооно.	2006 оны 7 дугаар сарын 06-ны өдөр
4	Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга	57.6.Улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагч болон Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгч, прокурор, Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд, Дэд ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, орон тооны гишүүн, Үндэсний статистикийн хорооны дарга, дэд дарга, Сонгуулийн ерөнхий хорооны дарга, нарийн бичгийн дарга, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, гишүүн, Үндэсний болон орон нутгийн аудитын газар, Авлигатай тэмцэх газрын удирдах ба гүйцэтгэх албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн нэмэгдлийн хэмжээ, зайлшгүй шаардлагатай бусад хангамжийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн хууль тогтоомжоор тогтооно.	2017 оны 12 дугаар сарын 07-ны өдөр
5	Монгол улсын шүүхийн тухай	6.7.Бүх шатны шүүхийн шүүгчийн орон тоо, цалингийн хэмжээг Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг харгалзан Улсын Их Хурал тогтооно.	2012 оны 3 дугаар сарын 07-ны өдөр

Харин хот, тосгоны захирагчийн албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 57 дугаар зүйлийн 57.5 дааь хэсэгт Засгийн газар тогтоохоор заажээ.

Өөрөөр хэлбэл авлигатай тэмцэх газар, аудитын газрын удирдах ба гүйцэтгэх албан тушаал болон бүх шатны шүүхийн шүүгч, прокурорын албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг салбарын хуулиудаар нь зохицуулж, энэ дагуу УИХ-аас эдгээр албан тушаалын цалингийн хэмжээг нь тусгайлан тогтоож байна.

Иймд Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.4 дэх хэсэгт заасныг үндэслэн дараахь улс төрийн албан тушаалын цалингийн хэмжээг тогтоохоор Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа. Үүнд:

1/ УИХ дахь нам, эвслийн бүлгийн ажлын албаны албан тушаалын сарын цалингийн хэмжээг Улсын Их Хурлын Тамгын газрын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтай адилтган боловсрууллаа.

2/ Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын албан тушаалын цалингийн хэмжээг сум, дүүргийн Засаг даргын албан тушаалын сарын цалинтай адилтгаж тогтоох талаар УИХ-ын тогтоолын төсөлд тусгасан болно.

3/ Шүүхийн шинжилгээний байгууллагын шинжээч, мэргэжилтэнг цагдаагийн байгууллагын офицер, ахлагчийн албан тушаалын цалинтай адилтган тогтоохоор тогтоолын төсөлд тусгалаа.

4/ Эдгээр албан тушаалын үндсэн цалингийн хэмжээг адилтгасан албан тушаалын үндсэн цалинтай адилтган тогтоохоор боловсруулав.

5/ Улсын Их Хуралд суудалтай нам, эвслийн бүлгийн ажлын албаны албан тушаалуудыг төрийн захиргааны албан тушаалын зэрэглэлтэй адилтгаж байхаар 1995 онд Улсын Их Хурлаас баталсан тогтоол, сум, дүүргийн иргэлийн төлөөлөгчдийн даргын албан тушаалыг тухайн шатны Засаг даргын даргын албан тушаалын цалинтай адил байхаар тогтоосон Засгийн газрын 2004 оны тогтоолыг хүчингүй болгохоор тогтоолын төсөлд тусгав.